

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2022.12.09

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
					Сүүлийн хагас жил		
Стратеги төлөвлөгөөний зорилго. “Газрын харилцааны салбарт мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлэх замаар газартай холбоотой төрийн үйлчилгээг цахимжуулж, үйл ажиллагааны шуурхай, мэргэжлийн, ил тод байдлыг хангахад оршино.”							
НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Зорилт 1. Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийгдсэн 6 сумын шинээр батлагдах нэрийн жагсаалтыг аймгийн Газар зүйн нэрийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Сумын тоо	1	6	Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн хурлыг 2022 оны 01 дүгээр сард болон 11 дүгээр сард 2 удаа зохион байгуулсан. Салбар зөвлөлийн эхний хурлаар өмнөх онуудад хийгдсэн газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажлуудын үр дүн, мэдээллийн сангийн засварыг хийх, энэ онд зохион байгуулагдах сумдын танилцуулгыг хэлэлцсэн. 2 дахь хуралдаанаар тус онд хийгдсэн 6 сумын газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын талаар хэлэлцэж хуралдааны шийдвэрийг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.	100
1.1.	Арга хэмжээ: Сумдын газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх мэдээллийн сан байгуулах ажлын тайланд дүгнэлт гаргах	-	Тухайн жилд ирүүлсэн тайлангийн тоо	7	3	Адаацаг 548, Дэлгэрцогт 405, Цагаандэлгэр 575, Эрдэнэдалай 637, Сайхан-Овоо 486, Дэлгэрхангай 606 нийт 3257 газар зүйн нэр 2004 онд Улсын Их Хурлаар батлагдсан байсныг уг ажлын хүрээнд 4245 болж шинээр тодруулсан 988 газар зүйн нэрийн хувийн хэрэг хөтөлж, УИХ-аар батлуулах хүсэлтийн маягыг бэлэн болгоод байна. 6 сумын тайланд дүгнэлт гаргасан.	100
1.2.	Арга хэмжээ: Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх	-	Тухайн жилд хийх хяналтын тоо	6	3	Аймгийн хэмжээнд УИХ-ын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан нийт 14819 газар зүйн нэрийг Геопортал үндэсний орон зайн өгөгдлийн сан дахь 16563 газар зүйн нэрээс шүүх батлагдсан болон батлагдаагүй нэрсийн мэдээллийг цахим системд шинэчлэх ажлыг ГЗБГЗЗГ-аас 2022 оны 10 дугаар сард зохион байгуулсан сургалтын үеэр гүйцэтгэн	100

						засварласан .shp файлыг холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. Мөн Адаацаг, Дэлгэрцогт, Цагаандэлгэр, Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Дэлгэрхангай сумдын ажилд “Хануйн цав” ХХК, “Дижитал мэппинг” ХХК, “Оюу имидж” ХХК нар гүйцэтгэгчээр ажилласан. Хээрийн тодруулалт болон суурин боловсруулалтын шатанд 7 удаа хяналт тавьж шаардлагатай заавар зөвлөмжийг өгч ажилласан.	
2	Зорилт 2. Газар ашиглалтын өөрчлөлтийг мониторингийн 233 цэг дээр үнэлж, газрын доройтлыг тодорхойлно.	-	Тухайн жилд мониторинг хийсэн цэгийн тоо	233	233	Аймгийн хэмжээнд 233 цэг дээр бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажил 08 дугаар сарын эхний 10 хоногт зохион байгуулсан.	100
2.1	Арга хэмжээ: Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах	-	Гүйцэтгэлийн хувь	100	100	Аймгийн хэмжээнд 15 сумын 233 цэгийн 6908382.55 га бэлчээрийн талбайд 2022 оны 08 дугаар сарын эхний 10 хоногт багтаан хээрийн хэмжилт боловсруулалтын ажлыг зохион байгуулж, үр дүнг нэгтгэн ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Мөн аймгийн 2022 оны бэлчээрийн өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлсэн ажлын тайланг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, доройтсон газруудад нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээ авах талаар 2023 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгаж ажиллах талаар чиглэл хүргүүлсэн.	100
2.2	Арга хэмжээ: Иргэн, ААН, байгууллагуудад газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэх талаар мэдэгдэл хүргүүлэх	-	Тухайн жилд хүргүүлсэн мэдэгдлийн тоо	130	140	Иргэн, ААН, байгууллагуудад газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэх талаар 153 нэгж талбарт мэдэгдэл хуудсыг хүргүүлсэн.	100
2.3	Арга хэмжээ: Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийлгэсэн иргэн, ААН, байгууллагуудын дүгнэлтийг цахимаар хүлээн авах	-	Тухайн жилд ирүүлсэн дүгнэлтийн тоо	85	71	2022 онд нийт 73 нэгж талбарын газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг цахим хэлбэрээр хүлээн авсан. Цахимаар ирүүлсэн дүгнэлтийг хянан шалгаж 67 дүгнэлтийг баталгаажуулж, шаардлага хангаагүй 6 нэгж талбарын дүгнэлтийг буцаан засварлуулсан.	100

3	Зорилт 3. Улсын төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламжийн гүйцэтгэлийн чанар 80 хувь байсныг 83 хувьд хүргэнэ.	УТ 26,458.8 ОНТ 7,795.4 ГХ 4,500.0	Гүйцэтгэлийн хувь	80	83	2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 24 барилга, 6 засвар, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 14 төсөл арга хэмжээ, гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 3 барилга байгууламж, нийт 47 барилга байгууламж, засвар тохижилтын ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэн ажилласан. Дээрх ажлуудын тухайн жилийн гүйцэтгэлийн дундаж хувь 91 хувьтай бөгөөд өмнөх оноос 11 хувийн өсөлттэй байна.	100
3.1	Арга хэмжээ: Нийгмийн дэд бүтэц (Сургууль, дотуур байр, цэцэрлэг, соёлын төв, эмнэлэг)-ийн барилгын засвар болон угсралтын ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх	-	Тухайн жилд хяналт гүйцэтгэсэн тоо	83	85	2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Сайхан-Овоо сумын 320 суудалтай сургууль, спорт заалны барилгад 5 удаа, Сайнцагаан сумын 960 суудалтай Говийн ирээдүй цогцолбор сургуулийн барилгад 11 удаа, Сайнцагаан сумын 640 суудалтай Хүмүүнлэг сургуулийн барилгад 1 удаа, Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгад 1 удаа, Дэлгэрцогт сумын 15 ортой цэцэрлэгийн барилгад 1 удаа, Гурвансайхан сумын 100 ортой дотуур байрны барилгад 8 удаа, Дэлгэрцогт сумын 240 суудалтай соёлын төвийн барилгад 5 удаа, Цагаандэлгэр сумын 240 суудалтай соёлын төвийн барилгад 3 удаа, Сайнцагаан сумын 100 ортой нэгдсэн эмнэлгийн барилгад 12 удаа, Говь-Угтаал сумын спорт заалны барилгад 3 удаа, Сайнцагаан сумын Ахмадын өргөөний барилгад 7 удаа, Сайнцагаан сумын Наадмын талбайн барилгын дуусгалтын ажилд 15 удаа, спорт заалны барилгын дээврийн засварын ажилд 3 удаа, Сайнцагаан суманд баригдаж буй усан бассейн бүхий спорт заалны барилгад 4 удаа, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Цагаандэлгэр сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажилд нийт 6 удаа, Өлзийт сумын сургууль, спорт заалны барилгыг хүзүүвчээр холбох ажилд 1 удаа,	100

						ТХДЖТеатрын гадна фасадны засварын ажилд 2 удаа тус тус захиалагчийн хяналт гүйцэтгэсэн. Нийт 90 удаа захиалагчийн хяналт хийж гүйцэтгэсэн.	
3.2	Арга хэмжээ: Нийгмийн дэд бүтэц (Сургууль, дотуур байр, цэцэрлэг, соёлын төв, эмнэлэг)-ийн барилгын засвар болон барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулах	-	Тухайн жилд ашиглалтад орсон барилгын тоо	9	10	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Наадмын талбайн барилгын ажлыг “Зуут констракшн” ХХК гүйцэтгэж 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр, Сайхан-Овоо сумын 320 суудалтай сургууль, спорт заалны барилгыг “Тэд констракшн” ХХК гүйцэтгэж 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр, Гурвансайхан сумын 100 ортой дотуур байрны барилгыг “Цагаан бургалтай” ХХК гүйцэтгэж 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдөр, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумдын сургуулийн цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн ажлыг “Винтер гарден” ХХК гүйцэтгэж 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр, Цагаандэлгэр сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн ажлыг “Мөнхийн үргэлжлэл” ХХК гүйцэтгэж 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр тус тус ашиглалтад оруулсан. Мөн аймгийн Биеийн тамир спортын газрын дээврийн засварын ажлыг “Мандал өргөө голомт” ХХК гүйцэтгэж 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр, ТХДЖТеатрын барилгын гадна фасадны засварын ажлыг “Хангада” ХХК гүйцэтгэж 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр, Сайхан-Овоо сумын соёлын төвийн өргөтгөлийн ажлыг “Хос соёмбот өргөө” ХХК гүйцэтгэж 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдөр тус тус ашиглалтад оруулсан. 2022 онд нийгмийн дэд бүтцийн 10 барилга угсралтын болон засварын ажлыг ашиглалтад оруулсан.	100
3.3	Арга хэмжээ: Инженерийн дэд бүтцийн барилгын угсралтын ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх	-	Тухайн жилд хяналт гүйцэтгэсэн тоо	17	20	Луус сумын төвийн усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлыг “Бурхант хясаат” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 25 хувьтай. Тус ажилд захиалагчийн хяналтыг 2 удаа	100

						<p>гүйцэтгэсэн.</p> <p>Сайхан-Овоо сумын төвийн усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн дуусгалтын ажлыг “Алтайн үндэс констракшн” ХХК гүйцэтгэж 2022 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан бөгөөд тус ажилд 3 удаа захиалагчийн хяналт гүйцэтгэсэн.</p> <p>“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713” төслийн нэмэлт санхүүжилтээр Эрдэнэдалай сумын усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, 50м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн ажлыг “Сайн констракшн” ХХК гүйцэтгэж 2022 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан бөгөөд тус ажилд 6 удаа захиалагчийн хяналт гүйцэтгэсэн.</p> <p>Аймгийн төвийн хоногт 3000м3 бохир ус цэвэрлэх хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж, гэр хорооллын 5,57км гадна бохир усны шугам сүлжээ”-ний ажлыг “Сайн констракшн” ХХК-тай 9,175 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж 2022 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан бөгөөд тус ажилд 12 удаа захиалагчийн хяналт гүйцэтгэсэн. Нийт 24 удаа захиалагчийн хяналт гүйцэтгэсэн.</p>	
3.4	Арга хэмжээ: Инженерийн дэд бүтцийн барилгын угсралтын ажлыг ашиглалтад оруулах	УТ 950.0 ГХ 2,000.0	Ашиглалтад орсон барилгын тоо	1	4	<p>Аймгийн төвийн хоногт 3000м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж, гэр хорооллын 5,57км гадна бохир усны шугам сүлжээний ажлыг “Сайн констракшн” ХХК гүйцэтгэж 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр, Эрдэнэдалай сумын ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, 50м³/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн ажлыг “Сайн констракшн” ХХК гүйцэтгэж 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр, Сайхан-Овоо сумын ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн дуусгалтын ажлыг “Алтайн үндэс констракшн” ХХК гүйцэтгэж 2022 оны 12 дугаар</p>	100

						сарын 15-ны өдөр, Хулд сумын төвийн нэгдсэн халаалтын зуух, дулаан хангамжийн шугам сүлжээний ажлыг "Хангайн илч дулаан" ХХК хувийн хөрөнгөөр гүйцэтгэж 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдөр тус тус ашиглалтад оруулсан. 2022 онд инженерийн дэд бүтцийн 4 барилга байгууламжийг ашиглалтад оруулсан.	
3.5	Арга хэмжээ: Сумдад баригдах орон сууцны барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх, ашиглалтад оруулах	-	Тухайн жилд хяналт гүйцэтгэсэн тоо	25	25	2022 оны жилийн эцсийн байдлаар Сайнцагаан суманд баригдаж буй 170 айлын 8 орон сууцны барилга угсралтын ажлын явцад нийт 35 удаа захиалагчийн хяналт гүйцэтгэсэн.	100
			Тухайн жилд ашиглалтад орсон барилгын тоо	3	4	2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Сайнцагаан сумын "Залуус хороолол"-д 145 айлын 7 орон сууцны барилгыг ашиглалтад оруулсан.	
3.6	Арга хэмжээ: Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгах, дахин төлөвлөх.	УТ 3,198.0	Тухайн жилд буулгасан барилга байгууламжийн тоо	1	2	2022 оны улсын төсөвт ашиглалтын шаардлага хангахгүй 2 барилгыг буулгаж, шинээр барихаар хөрөнгийг батлуулсан. Үүнд: Сайнцагаан сумын 150 ортой 2 дугаар цэцэрлэгийн барилгын ажлыг "Энхбаялаг констракшн" ХХК 2,71 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан бөгөөд буулгалтын ажил хийгдсэн. Мөн Сайнцагаан сумын 640 суудалтай Хүмүүнлэг 3 дугаар сургууль, спорт заалны барилга угсралтын ажлыг "Си Эйч Би Жи констракшн" ХХК 9,54 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан бөгөөд буулгалтын ажил хийгдсэн. Дээрх 2 ажлын тухайн жилийн гүйцэтгэл 100 хувьтай хэрэгжсэн.	100
4	Зорилт 4.3 сумыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгоно.	ОНТ 400.0	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болсон сумын тоо	1	4	Баянжаргалан, Луус, Өндөршил сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Сонголт дизайн" ХХК гүйцэтгэж 2022 оны 09 дүгээр сард хүлээлгэн өгсөн. Мөн Эрдэнэдалай, Хулд, Дэлгэрхангай, Дэрэн, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж байна.	100
4.1	Арга хэмжээ: Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний	-	Батлагдсан зургийн	6	9	2022 онд Баянжаргалан, Эрдэнэдалай сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	100

	зургийн даалгаврыг боловсруулж, батлуулах		даалгаврын тоо			боловсруулах зургийн даалгаврыг ГЗБГЗЗГ-аар, Цагаан суваргын аялал жуулчлалын бүсийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврыг БХБЯ болон ГЗБГЗЗГ-ын холбогдох албан тушаалтнуудаар тус тус хянуулан аймгийн Засаг даргаар батлуулан захиалагч байгууллагуудад хүргүүлсэн.	
4.2	Арга хэмжээ: Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд санал өгөх	-	Хүргүүлсэн саналын тоо	2	4	Баянжаргалан, Өндөршил, Дэлгэрхангай сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тус бүр 1 удаа санал хүргүүлсэн.	100
5	Зорилт 5. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн хүрээнд жендэрийн салбарын төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлж ажиллана.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбарын төлөвлөгөөний тус байгууллагад холбогдолтой заалтуудын жилийн эцсийн хэрэгжилтийг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 1/480 тоот албан бичгээр аймгийн ЗДТГазарт хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь. Хүний эрхийн үндэсний комиссоос НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төсөл, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Койка)-тай хамтран жендэрийн мэдрэмжтэй эрэгтэй удирдагчдыг орон нутгийн түвшинд шалгаруулсан. Дээрх сонгон шалгаруулалтад 19 аймгийн 170 гаруй байгууллагын 1800 гаруй албан хаагч хамрагдаж аймаг бүрт гурван салбараар жендэрийн мэдрэмжтэй 29 удирдагчийг шалгаруулсан ба тус байгууллагын дарга Э.Чагнаадорж шалгарсан.	100
5.1	Арга хэмжээ: Салбарын хүний нөөцийн нас, хүйсээр ангилсан мэдээллийн санг бий болгох	-	Гүйцэтгэлийн хувиар	0	100	Тус аймгийн барилгын салбарын инженер, техникийн ажилтан болон мэргэжилтэй ажилчдын мэдээллийн санг үүсгэж судалгааг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 1/185 дугаартай албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн.	100
5.2	Арга хэмжээ: “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн сургалт зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	14	15	Албан хаагчдын ажлын байран дээрх мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор Хүний эрхийн үндэсний комиссын Дундговь аймаг дахь референт Т.Баярцэцэг “Хүний эрхийн үндсэн	100

						ойлголт”, “Жендэрийн эрх тэгш байдал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Мөн сумдын Газрын даамлуудын сургалтын үеэр дээрх сургалтыг дахин зохион байгуулсан. Нийт 2 удаагийн сургалтад тус бүр 28 албан хаагч хамрагдсан.	
ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
6	Зорилт 6. Газрын төлбөрийн нэхэмжлэлийг үүсгэж, дуудлага худалдааны орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлнэ.	-	Гүйцэтгэлийн хувиар	100	100	2022 онд аймгийн хэмжээнд нийт 7081 нэгж талбарын ногдуулалтыг үүсгэж 6838 нэгж талбарын нэхэмжлэлийг үүсгэсэн. 1882 нэгж талбарын газрын төлбөрийн төлөлт бүртгэгдэж 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 450,5 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн. Сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдаагаар олгохоор тусгагдсан 56 байршилд 78 удаа дуудлага худалдааг цахимаар зохион байгуулж Газрын дуудлага худалдаа, газрын суурь үнийн орлого 88 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээс газрын дуудлага худалдаанаас 74,8 сая төгрөг, газрын суурь үнэ 83,0 сая төгрөг, нийт 157,8 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлээд байна.	100
6.1	Арга хэмжээ: Газрын төлбөрийн бүсийн хил зааг, хувь хэмжээг шинэчлэн тогтоох тогтоолыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх	-	Батлагдсан тогтоолын тоо	0	1	Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтад нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан газрын төлбөр ногдуулах итгэлцүүрийг шинэчлэн тогтоох ажлыг Захиргааны ерөнхий тухай хуулийн дагуу зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 07 дугаар тогтоолоор тус аймгийн “Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүр, төлбөрийн хэмжээ”-г батлуулан Хууль зүйн яаманд хянуулж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. Уг тогтоолын дагуу аймгийн хэмжээнд хүчинтэй төлөвт байгаа нэгж талбарын газрын төлбөрийг	100

						шинэчлэн бодуулсан.	
6.2	Арга хэмжээ: Газрын төлбөрийг ногдуулж, нэхэмжлэлийг үүсгэх	-	Нэгж талбарын тоо	6300	6350	<p>ГЗБГЗЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 1/194 дүгээр албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 2022 оны газрын төлбөрийн нэхэмжлэлийг сумдын ИТХ-аас 2018 онд тогтоосон итгэлцүүрийн дагуу хуулийн хугацаанд буюу 2022 оны 02 дугаар сарын 07-10-ны өдрүүдэд үүсгэн газрын төлбөрийг төвлөрүүлсэн.</p> <p>2022 онд аймгийн хэмжээнд нийт 7081 нэгж талбарын ногдуулалтыг үүсгэж 6838 нэгж талбарын нэхэмжлэлийг үүсгэсэн. 1882 нэгж талбарын газрын төлбөрийн төлөлт бүртгэгдсэн байна.</p> <p>Татвар төлөгчөөр бүртгэгдээгүй, газар эзэмшигч нас барсан, регистрийн дугаар зөрүүтэй, ТИН дугаар бүртгэлгүй зэрэг шалтгааны улмаас 243 нэгж талбарын нэхэмжлэл үүсээгүй байна.</p> <p>2022 онд газрын төлбөрийн орлого 362 сая төгрөг төвлөрүүлэхээс 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар 450,5 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.</p>	100
6.3	Арга хэмжээ: Газрын биржийн цахим системээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа зохион байгуулах.	-	Дуудлага худалдаа зохион байгуулагдсан тоо	52	80	<p>Сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдаагаар олгохоор тусгагдсан 56 байршилд 78 удаа дуудлага худалдааг цахимаар зохион байгуулснаас 22 дуудлага худалдааг дахин зарласан ба 26 дуудлага худалдаа амжилттай болж, 52 дуудлага худалдаа үнэ төлөөгүй, оролцогчгүй зэрэг шалтгааны улмаас хүчингүй болсон.</p> <p>Танхимаар дуудлага худалдаа зохион байгуулаагүй.</p> <p>Аймгийн хэмжээнд 9 байршилд салхин сэнсний судалгааны талбайн зориулалтаар төсөл сонгон шалгаруулалтыг Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын дагуу зохион байгуулж, гэрээг байгуулан тухайн шатны Засаг даргын захирамжаар газар ашиглуулсан.</p>	92.8

						Тус аймгийн дуудлага худалдааны орлогын дансанд (100080000967 Ду.Газрын дуудлага худалдааны орлого) газрын дуудлага худалдааны орлого, дэнчин, газрын суурь үнийг төвлөрүүлдэг. Газрын дуудлага худалдаа, газрын суурь үнийн орлого 88 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээс газрын дуудлага худалдаанаас 74,8 сая төгрөг, газрын суурь үнэ 83,0 сая төгрөг, нийт 157,8 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлээд байна.	
7	Зорилт 7. Аймгийн хэмжээнд газар өмчлөлийн хувь 36,2 байсныг 36,3 хувьд хүргэнэ.	-	Газар өмчилсөн иргэдийн тоог аймгийн нийт хүн амд харьцуулсан хувь	36,2	36,3	2022 онд аймгийн хэмжээнд нийт 1452 иргэнд 111,86 га газар өмчлүүлэхээр төлөвлөж 1045 иргэнд 79.21 га газрыг өмчлүүлсэн ба өмчлөлийн хувь 36,9 болж өссөн.	100
7.1	Арга хэмжээ: 2022 онд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд өмчлүүлэхээр төлөвлөсөн газрыг өмчлүүлэх	-	Тухайн жилд ирүүлсэн өргөдлийн тоо	17145	700	2022 онд аймгийн хэмжээнд нийт 1452 иргэнд 111,86 га газар өмчлүүлэхээр төлөвлөснөөс 1045 иргэнд 79.21 га газрыг өмчлүүлсэн. Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 1/451 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн	100
7.2	Арга хэмжээ: Монгол улсын иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг сум бүрээр нэгтгэн боловсруулж, аймгийн ИТХ-д хүргүүлэх	-	ИТХ-ын тогтоолын тоо	1	1	Аймаг, нийслэлийн хэмжээнд 2023 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг ИТХ-аар хэлэлцүүлж 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор батлуулан 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 2/323 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.	100
8	Зорилт 8. Газрын маргааны асуудал 56 байсныг 37 болгон бууруулна.	-	Тухайн жилд шийдвэрлэсэн маргааны тоо	56	19	2022 онд газрын 25 маргааныг шийдвэрлэсэн.	100
8.1	Арга хэмжээ: Сумдын хилийн цэсийн гадна олгогдсон өвөлжөө, хаваржааны газрыг хуулийн дагуу харьяалах сумын Засаг даргын шийдвэр гаргуулах	-	Тухайн жилд ирүүлсэн өргөдлийн тоогоор	15	10	2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 25 нэгж талбарыг төлөвлөн харьяа сумын Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн.	100

8.2	Арга хэмжээ: Хилийн цэсийн гадна олгогдсон өвөлжөө, хаваржааны газрыг харьяалах сумдын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал оруулах	-	Тухайн жилд төлөвлөгөөнд тусгасан нэгж талбарын тоо	19	5	Сумдын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд хилийн цэсийн гадна олгогдсон 99 нэгж талбарыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр саналыг хүргүүлсэн.	100
8.3	Арга хэмжээ: Аймаг хоорондын хил дамнан олгогдсон өвөлжөө, хаваржааны газрын маргааныг шийдвэрлүүлэхээр 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах саналыг хүргүүлэх	-	Тухайн жилд хүргүүлсэн саналын тоо	2	2	Өвөрхангай, Төв аймгийн хил залгаа сумдад харьяалагддаг өвөлжөө, хаваржааны газраа 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах саналыг цахимаар хэрхэн өгөх талаар заавар, зөвлөмжийг иргэдэд өгсөн. Цагаандэлгэр сумын Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны 1/194 тоот албан бичгээр Төв аймгийн Баянцагаан сумруу, Эрдэнэдалай сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 1/226 тоот албан бичгээр Төв аймгийн Бүрэн сумруу нийт 12 иргэний өвөлжөө, хаваржааны газрыг тухайн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг хүргүүлсэн.	100
9	Зорилт 9. 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу олгогдсон газрыг 100 хувь цахимжуулна.	-	Тухайн жилийн гүйцэтгэлийн хувь	100	100	2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан өмчлөл, эзэмшил, ашиглалтаар 1337 нэгж талбарыг олгосон бөгөөд 100 хувь цахим системд бүртгэж баталгаажуулсан.	100
9.1	Арга хэмжээ: 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмшүүлж, ашиглуулах	-	Тухайн жилд эзэмшүүлж ашиглуулсан нэгж талбарын тоо	216	113	2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбаруудаас 50 байршилд дуудлага худалдааг цахимаар зарласны 22 газар худалдагдсан, өргөдлийн дагуу газрын кадастрын цахим системд нийт 292 өргөдлийг бүртгэж шийдвэрлэлээ. Үүнд шинээр газар эзэмших 285 иргэн, хуулийн этгээдэд 1473.1 га, шинээр газар ашиглах 7 ААН-д 968154.96 га газрыг цахим системд бүртгэн эзэмшүүлж, ашиглуулсан байна.	100
9.2	Арга хэмжээ: Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд нэгж талбарын цахим хувийн	-	Тухайн жилийн гүйцэтгэлийн хувь	100	100	Аймгийн хэмжээнд 2003 оноос хойш иргэн, аж ахуй нэгж, байгууллагад эзэмшүүлж, ашиглуулж, өмчлүүлсэн газрын нийт 24600 нэгж талбарын цаасан хувийн хэргийг цахимжуулж, Газрын	100

	хэргийг холбогдох журмын дагуу бүртгэж, оруулах					кадастрын мэдээллийн сантай холбох ажлыг зохион байгуулж ГХГЗЗГ-ын даргын 2016 оны А/169 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Нэгж талбарын хувийн хэрэг”-т байх шаардлагатай материалыг бүрдүүлж, аймгийн хэмжээнд 300,000 гаруй хуудас цаасан баримтыг цахимжуулсан.	
10	Зорилт 10. Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана.	-	Гүйцэтгэлийн хувь	100	100	Байгууллагын үйл ажиллагааг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбар, Дундговийн амьдрал сониноор тогтмол сурталчилсан. Газрын харилцааны үйл ажиллагаа цахимжсантай холбогдуулан иргэд, олон нийт өөртөө үйлчлэх киоск, цахим мэдээллийн буланг ажиллуулж байгаа ба иргэд газартай холбоотой 42 төрлийн үйлчилгээг цахимаар авах нөхцөл боломж бүрэн бүрдсэн.	100
10.1	Арга хэмжээ: Аймаг орон нутгийн мэдээлэл болон байгууллагын үйл ажиллагааг мэдээллийн самбар, хэвлэл мэдээлэл, олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлах	-	Ил тод байршуулсын мэдээллийн тоо	150	150	Байгууллагын цахим хуудас /www.dundgovi.gazar.gov.mn/ болон facebook дахь хуудас /Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/, Дундговь аймгийн нэгдсэн веб хуудас /www.dundgovi.gov.mn/-д салбарын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ, мэдээллийг тухай бүр шинэчлэн ажилласан. Хэвлэл мэдээлэл, олон нийтийн цахим сүлжээгээр 165 мэдээ, мэдээллийн самбарт 24 мэдээ мэдээллийг оруулан шинэчилсэн байна. Газрын кадастрын цахим систем болох eazar.gov.mn сайтыг сурталчлах, хэрэглээнд нэвтрүүлэх талаар ГЗБГЗЗГазраас гаргасан мэдээ мэдээлэл, видео шторк болон өөрийн байгууллагаас санаачлан бэлтгэсэн видео шторк, гарын авлагыг байгууллагын болон сумдын газрын даамлуудын хөтөлж буй олон нийтийн цахим хуудсаар сурталчилсан.	100
10.2	Арга хэмжээ. Байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудсыг идэвхжүүлж,	-	Цахим хуудасны хандалтын тоо	2700	3000	Байгууллагын цахим хуудас /www.dundgovi.gazar.gov.mn/-нд сард дунджаар 3700 иргэн хандаж орон нутгийн болон	100

	хандалтын тоог нэмэгдүүлэн, дагагчийн тоог өсгөх					салбарын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ, мэдээллийг авдаг. Жилийн эцсийн байдлаар 44,000 удаа цахим хуудсанд хандсан байна.	
		-	Фэйсбүүк хуудасны дагагчийн тоо	4100	5000	Байгууллагын facebook хуудас /Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/-нд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ, мэдээллийг тогтмол байршуулдаг. 2022 онд цахим хуудасны дагагчийн тоо 5069 болж 969 дагагчаар нэмэгдсэн байна.	100
10.3	Арга хэмжээ: Авлигын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ХЭЗХэлтэст хүргүүлэх	-	Тухайн жилийн тайлангийн тоо	1	1	Авлигын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх байгууллагын төлөвлөгөөг аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө болон агентлагийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж 14 зорилгын хүрээнд 50 арга хэмжээг төлөвлөн Ерөнхий эрх бүхий албан тушаалтнаар хянуулж, тус байгууллагын даргаар 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлэн, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр албан бичгээр ГЗБГЗЗГ-т болон аймгийн ЗДТГ-т тус тус хүргүүлсэн.	100
10.4	Арга хэмжээ: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах	-	Тухайн жилийн гүйцэтгэлийн хувь	100	100	Байгууллагын шилэн дансны мэдээллийг сар бүр байршуулан ажиллаж байгаа бөгөөд нийт 145 мэдээллийг хугацаанд нь оруулж, хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй бөгөөд гүйцэтгэл 100 хувь байна.	100
10.5	Арга хэмжээ: Сумдад нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг зохион байгуулах		Тухайн жилд зохион байгуулсан сумын тоо	-	6	Газрын харилцааны үйлчилгээг иргэдэд хүргэх, www.egazar.gov.mn газрын нэгдсэн цахим системийг сурталчлах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 13-ний өдрийн хооронд Адаацаг, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Өлзийт, Гурвансайхан, Говь-Угтаал, Дэрэн сумдад	100

						“Нээлттэй хаалга”-ны өдөрлөгийг зохион байгуулж 400 гаруй иргэн, ААН, байгууллагад газрын харилцааны үйлчилгээг үзүүлсэн.	
11	Зорилт 11. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахимжуулна.	-	Цахимаар ирүүлсэн өргөдлийн тоо	86	160	Газрын кадастрын цахим системд иргэн, аж ахуй нэгжээс нийт 930 өргөдөл хүсэлт ирсэн. Үүнээс хавсралт материал дутуу болон буруу материал илгээсэн 22 өргөдлийг буцааж, 908 өргөдөл хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэж ажилласан.	100
11.1	Арга хэмжээ: Барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг www.urban.gov.mn сайтаар олгох	-	Тухайн жилд цахимаар олгосон архитектур төлөвлөлтийн даалгаврын тоо	14	15	2022 оны жилийн эцсийн байдлаар “Хот байгуулалтын кадастрын цахим систем”-ээр 21 барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон.	100
11.2	Арга хэмжээ: Барилга байгууламжийн ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг www.urban.gov.mn сайтаар олгох	-	Тухайн жилд цахимаар олгосон зөвшөөрлийн тоо	4	5	2022 онд “Хот байгуулалтын кадастрын цахим систем”-ээр 29 барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон.	100
11.3	Арга хэмжээ: Газрын харилцааны үйлчилгээг www.egazar.gov.mn сайтаар үзүүлэх	-	Тухайн жилд цахимаар үйлчилгээ авсан иргэдийн тоо	291	350	Газрын кадастрын цахим систем www.egazar.gov.mn сайтаар дамжуулан гэрчилгээ 75 иргэн, кадастрын зураг 386 иргэн, гэрээ 39 иргэн, барьцаанд бүртгүүлэх лавлагааг 69 иргэн хэвлэж авсан байна. Нийт цахим системээр 569 удаа үйлчилгээ авсан.	100
11.4	www.emongolia.mn сайтаар дамжуулан газрын харилцааны чиглэлээр төрийн үйлчилгээг авах иргэдийн тоог нэмэгдүүлэх	-	Тухайн жилд цахимаар үйлчилгээ авсан иргэдийн тоо	291	400	www.emongolia.mn сайтаар дамжуулан газрын харилцааны болон барилга хот байгуулалтын чиглэлээр 598 иргэн, хуулийн этгээд үйлчилгээ авсан байна.	100
12	Зорилт 12. Барилга байгууламж, зам талбайн тохижилт, гадна өнгө үзэмжийг сайжруулна.	УТ ОНТ 1,607.9	Гүйцэтгэлийн хувь	100	100	Тус онд аймгийн 80 жилийн ой тохиосонтой холбогдуулан аж ахуй нэгж байгууллагуудын гадна фасадны өнгө үзэмжийг сайжруулах, зам талбайн тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээд аймгийн ЗДТГ-ын барилгын гадна фасадыг 3,0 сая төгрөгөөр будаж засварласан. Мөн Г.Чагдаржавын талбайн зам дагуух ногоон байгууламжийг	100

						хэлбэлжүүлэн засаж, орчны цэвэрлэгээг хийсэн.	
12.1	Арга хэмжээ: Архитектур төлөвлөлтийн даалгаварт барилгын гадна фасадны өнгө, материалын талаар тусгах	-	Гүйцэтгэлийн хувь	100	100	2022 оны жилийн эцсийн байдлаар 21 барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон бөгөөд тус даалгаварт барилгын гадна фасадны өнгө болон материалын талаар тусгаж, шаардлага хангасан 15 загвар зургийг баталсан.	100
12.2	Арга хэмжээ: Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих зам талбайн тохижилт, барилгын гадна фасадны засварын ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх	-	Тухайн жилд гүйцэтгэсэн хяналтын тоо	8	10	Аймгийн төвийн гэр хороололд 3 газарт хүүхдийн тоглоомын жишиг талбай байгуулах ажилд 4 удаа, аймгийн төвийн айраг 9 гудамжны тохижилтын ажилд 2 удаа, ТХДЖТеатрын барилгын гадна фасадны засварын ажилд 2 удаа, Сайхан-Овоо сумын соёлын төвийн барилгын засварын ажилд 2 удаа тус тус захиалагчийн хяналт гүйцэтгэж тайланг аймгийн ЗДТГ-т тухай бүрт хүргүүлсэн.	100
12.3	Арга хэмжээ: Жилд тарих модны тоог нэмэгдүүлэх	-	Тухайн жилд тарьсан модны тоо	142	145	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дундговь-Улаанбаатар чиглэлийн автозам дагуу тарьсан модны нөхөн тарилтыг хийж улиас, хайлаас, шар хуайс төрлийн нийт 147 ширхэг мод тарьсан.	100
12.4	Арга хэмжээ: Байгууллагын гадна хог ангилан ялгах савыг байршуулах	БТ 0.3	Байршуулсан хог ангилан ялгах савын тоо	0	1	Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн хүрээнд ЗДТГ-ын гадна тохижилтын ажлыг хийх болсон ба уг ажлын хүрээнд 1 загварын хог ангилан ялгах сав авах саналыг аймгийн ЗДТГ-аас гаргасан тул дээрх үйл ажиллагаанд тус байгууллагаас 1.0 сая төгрөгийг хандивласан.	100
12.5	Арга хэмжээ: Барилга болон тохижилтын ажлын зургийн даалгаварт ангилан ялгах хогийн сав байршуулах талаар тусгах	-	Тухайн жилд батлагдсан зургийн даалгаврын тоо	0	5	Нийгмийн дэд бүтцийн 3 барилга, 2 тохижилтын ажлын зургийн даалгаварт ангилан ялгах хогийн байршуулах талаар заалт тусгаж баталсан.	100
13	Зорилт 13. Байгууллагын соёлыг дэлгэрүүлж, ёс зүйтэй албан хаагчдыг бүрдүүлж, харилцаа, хандлагыг сайжруулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2	Албан хаагчдын ажлын байран дээрх мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор “Мэдээллийн цаг” сургалтын арга хэмжээг 2017 оноос хойш тогтмол зохион байгуулж хэвшсэн. 2022 онд ажлын байран дээрх сургалтыг сар бүр зохион байгуулахаар төлөвлөж, 10 удаа зохион байгуулсан байна. Сургалтад хамрагдсан албан хаагчид бусад албан хаагчдад хамрагдсан	100

						сургалтын талаар мэдээлэл өгдөг. Мөн хувь хүний хөгжил, харилцаа, танин мэдэхүйн чиглэлээр сургалт зохион байгуулж, санал солилцдог ба ТАСЗ-өөс “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвийн хүрээнд 2 удаагийн сургалт зохион байгуулагдсан.	
13.1	Арга хэмжээ: Албан хаагчдад харилцаа, хандлага, ёс зүй сэдэвт сургалтыг зохион байгуулах	БТ 0.5	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	0	24	Албан хаагчдын харилцаа хандлага, манлайлах ур чадварыг дээшлүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор Сэтгэл зүйч, Лектор Г.Наранбаатарын “Хандлагын үндэс ямар байна, амжилтын өндөр тийм байна” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад тус байгууллагын албан хаагчид, сумдын Газрын даамлууд (нийт 29 албан хаагчтай) бүрэн хамрагдсан. Мөн Төрийн албаны салбар зөвлөлөөс “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтуудыг тус байгууллагын албан хаагчид, сумдын Газрын даамлуудад зохион байгуулсан.	100
13.2	Арга хэмжээ: Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд төсөл бичиж, төрийн бус байгууллагад хүргүүлэх	-	Гүйцэтгэлийн хувь	-	100	Ашгийн бус төслийн сургалтад тус байгууллагаас 1 албан хаагч хамрагдсан. Тус байгууллага 2021 онд “Мандалговь цэцэрлэгт хүрээлэн”-гийн зураг төсвийг боловсруулан магадлалаар батлуулж аймгийн удирдлагуудад хүлээлгэн өгсөн. Шинээр төлөвлөж буй “ Мандалговь хотын цэцэрлэгт хүрээлэн ”-гийн 45 га талбайг бүхэлд нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй гэрэлтүүлэгтэй болгож иргэдийн эрүүл аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Мандалговь цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлэг” төслийг бичиж аймгийн ЗДТГ-ын ТЗУХэлтэст файлаар хүргүүлсэн.	100
13.3	Арга хэмжээ: Газрын даамалгүй сумдын боловсон хүчнийг бэлтгэх	-	Төрийн албаны шалгалтын өмнөх сургалтад хамруулсан эсэх	-	1	2022 оны 01 дүгээр сард тус аймгийн 6 сум Газрын даамалгүй байсан ба сул орон тооны захиалгыг ТАСЗ-д 2 удаа хүргүүлж ерөнхий болон тусгай шалгалтад бүртгүүлсэн иргэдэд мэдээлэл өгч, Говь-Угтаал, Өлзийт сумдын Газрын даамлын албан тушаалд Төрийн	100

			(тийм-1, үгүй-0)			албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалтын дагуу төрийн албаны нөөцөөс нөхөж томилсон. Тус байгууллагад ажиллаж байсан 2 албан хаагчийг төрийн албаны шалгалтын өмнөх сургалтад хамруулсан. ТАСЗ-өөс ирүүлсэн дүгнэлтийн дагуу дээрх 3 албан хаагчийг төрийн жинхэнэ албан хаагчаар томилсон.	
Зорилтын дундаж хувь							100
Арга хэмжээний дундаж хувь							99.8
Хэрэгжилтийн дундаж хувь							99.9

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Ц.МӨНХБАТ/

Тэмдэг

(огноо)

.....

Төлөвлөгөө тайлагнасан:

Төсвийн Шууд захирагч

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

...../Э.ЧАГНААДОРЖ/
(гарын үсэг)

Тэмдэг

(огноо)

.....